



БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Барилга угсралтын ажлын үнийн өсөлтийн
2012 оны индекс батлах тухай

“Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 336 дугаар тогтоолын 2 дугаар заалт, Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 5 дугаар хуралдааны зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга угсралтын ажлын үнийн өсөлтийн 2012 оны индексийг эдийн засгийн тооцоо, судалгаа, хөрөнгө оруулалтын урьдчилсан төлөвлөлтөнд хэрэглэх зорилгоор хавсралтаар баталсугай.

2. Уг индексийг салбарын хэвлэл, мэдээллээр нийтэд сурталчлах, харьцуулалт, судалгаа, тооцооны ажилд хэрэглэх ажлыг зохион байгуулахыг Барилгын хөгжлийн төв /Б.Баярсайхан/-д даалгасугай.



Ц.БАЯРСАЙХАН